

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

АУДИТЫН КОД: АГГ-2022/22-ШТА-ГА

ТӨРИЙН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2022 он



Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Ж.Болормаа

Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитор С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудитор Н.Хулан

Утас: 70533552 Цахим хаяг: Khulann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр	Товчилсон үгийн тайлбар	2
	Хүснэгт, график, зургийн жагсаалт	2-3
Аудитын менежер: Т.Хонгорзул	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3-4
Ахлах аудитор: Ж.Болормаа	Бүлэг 1. Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын үр нөлөөг орон нутагт сайжруулах шаардлагатай байна	5
Аудитор: С.Одончимэг Н.Хулан	1.1 Шинээр байгуулж байгаа аж ахуй нэгжүүдийг тооцоо судалгаанд үндэслээгүй байна	5-6
	1.2 Орон нутагт хэрэгжүүлж буй өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлого үр дүнтэй байна	6-7
	Бүлэг 2. Хуулийн этгээдүүд удирдлагын зардлаа үндэслэлтэй төлөвлөөгүй нь үр ашиггүй зардал гарах үндэслэл болж байна	7
	2.1 Хуулийн этгээдүүд эдийн засгийн зорилтот түвшнээ үндэслэлтэй төлөвлөдөггүй байна	7-14
	2.2 Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах шаардлагатай байна	14-17
2022 оны 06 дугаар сар	Бүлэг 3. Хуулийн этгээдэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна	17
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.	3.1 Сайн засаглалыг төлөвшүүлэхэд төрийн байгууллагуудийн хяналт, оролцоо чухал байна	17-21
	3.2 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг бүрэн хангаагүй байна	21-22
Тайланг ӨМТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.	Дүгнэлт	23
	Зөвлөмж	24
	Холбогдох байгууллагын санал	25
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 305 тоот	Дарга, Тэргүүлэх аудиторовын тушаал	26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УИХ	Улсын Их хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
СЯ	Сангийн яам
ЭХС	Эрчим хүчний сайд
БОАЖС	Байгаль орчин аялал жуучлалын сайд
БОАЖГ	Байгаль орчин аялал жуучлалын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭХЗЗ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТХ	Татварын хэлтэс
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨОААН	Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ДЦС	Дулааны цахилгаан станц
ТӨХК	Төрийн өмч хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
АЗД	Аймгийн засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ХБТХОХ,	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хөрөнгө оруулалтын хэлтэс
ЦДШ	Цахилган дамжуулах шугам
ОСК	Орон сууц корпораци
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Хүснэгт, Дүрслэл, графикийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	2016-2020 онд худалдан хувьчилсан хөрөнгийн судалгаа	6
Хүснэгт 2	ОНӨОААН болон ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл	7-8
Хүснэгт 3	Тавантолгой ХК-ны техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэл	8
Хүснэгт 4	Гүний ус ХХК-ний үйлдвэрлэл, борлуулалт	9
Хүснэгт 5	Гүний ус ХХК-ны үндсэн үзүүлэлт зорилтот түвшин сүүлийн 3 жилийн байдлаар	9
Хүснэгт 6	Гэрээний хэрэгжилт	10
Хүснэгт 7	Тавантолгой ХК-ний борлуулалтын үнэ тогтоолт	11

Хүснэгт 8	Цэвэр, бохир усны үнэ, үйлчилгээний тариф, суурь хураамж	13
Хүснэгт 9	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	14
Хүснэгт 10	Санхүүгийн тайланд тусгасан авлага	14
Хүснэгт 11	Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, төлбөрийн дүн	15
Хүснэгт 12	Санхүүгийн тайланд тусгасан татварын өр	15
Хүснэгт 13	Төрийн байгууллагуудын хийсэн хяналт, шалгалтын тоо	17
Хүснэгт 14	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хэрэгжүүлсэн шалгалт	19
Хүснэгт 15	Хуулийн дагуу хийгдсэн санхүүгийн тайлангийн аудит	19-20
График 1	Тавантолгой ХК-ийн Монгол Улсын нүүрсний экспортод эзлэх хувь	8

Аудитын зорилт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”-д заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Хамрах хүрээ:

Аудитад түүвэрлэн сонгосон ОНӨААТҮГ, ОНӨОААН-ын 2019-2021 оны үйл ажиллагаа, засаглал, үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг хамруулан шалгалаа.

Хүндрэл, бэрхшээл:

Тавантолгой ХК нь аудитад шаардлагатай баримт материалыг бүрэн ирүүлээгүй, судалгаа, мэдээллийг цаг хугацаанд гаргаж өгөөгүй зэрэг нь компанийн засаглалыг дэлгэрэнгүй үзэх нөхцөл бололцоог хязгаарласан болно.

Аудитад ашигласан шалгуур:

Мөн шатахуун болон албан томилолтын зардал хязгаарлагдмал байгаагаас талбарт ажиллаагүй, аудиторуд аудитад давхардаж орсон нь аудит гүйцэтгэхэд хүндрэл үүсгэж байлаа.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Үүнд:

- Компанийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2006, 2021/
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Компанийн тухай хууль
- Иргэний хууль
- Шилэн дансны тухай хууль
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр”
- Төрийн өмчит хуулийн этгээдийн байгууллагын дүрэм, журам,
- Байгууллагын дотоод дүрэм, журам

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул арга зүйгээр хангаж, ахлах аудитор Ж.Болормаа, аудитор С.Одончимэг, Н.Хулан нар 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1 Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын үр нөлөөг орон нутагт сайжруулах шаардлагатай байна

1.1 Шинээр байгуулж байгаа аж ахуй нэгжүүдийг тооцоо судалгаанд үндэслээгүй байна

1.1.1 Өмнөговь аймгийн хэмжээнд 16 ОНӨААТҮГ дулаан үйлдвэрлэх, хуваарилах, хангах, цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа явуулж байгаа, ОНӨОААН болох Гүний ус ХХК ус хуримтлуулан, ариутган түгээх үйлчилгээ, тоног төхөөрөмж угсралтын ажиллагаа, сантехник угсралт, Тавантолгой ХК чулуун нүүрс олборлолт, тээвэр, гадаад дотоод худалдаа, кокс үйлдвэрлэл үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

1.1.2 Өмнөговь аймгийн Хөгжил, хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, нийлүүлэх, сургалт, судалгааны ажил явуулахаар үйл ажиллагааны чиглэл нь батлагдсан боловч хэрэгжүүлж ажилладаггүй байна.

1.1.3 Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэн хилийн боомтоор ашигт малтмалын тээвэрлэлт хийж байгаа тээврийн хэрэгсэл бүрээс төлбөр авч, зарцуулж байгааг үйл ажиллагааны чиглэлдээ тусгаагүй байна.

1.1.4 Сум орон нутгийн удирдлагууд нөхцөл байдлыг бүрэн судлаагүй шийдвэр гаргаснаас 1 суманд ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийг үүсгэн байгуулсан байна. Үүнд:

- Гурвантэс суманд Шугшаа уул
- Цогтцэций суманд Тэгш дүүрэн тохижилт
- Ханбогд суманд Хот тохижилт
- Сэврэй суманд Нийтлэг үйлчилгээний газар

1.1.5 Гүний ус ХХК-ны 1 гишүүн, Гурван сайхан орон сууц корпораци ХХК-ны 8 гишүүн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаагүй байгаа нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8¹ дахь заалттай нийцэхгүй байна.

1.1.6 Гүний ус ХХК Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2² -д заасны дагуу дүрэмдээ хараат бус гишүүнтэй байхаар тусгайлан зааж өгөөгүй тул нэр дэвшүүлэх хороо, аудитын хороо, цалин урамшууллын хороо байхгүй байна.

1.1.7 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулж Гүний ус ХХК 2019 онд 23.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нэгж хувьцаанд 78 мөнгө, 2020 онд 17.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж нэгж хувьцаанд 29 мөнгөөр тооцож ногдол ашиг хуваарилсан байна.

1.1.8 Таван толгой ХК ТУЗ нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй, үйл ажиллагааны 3 хороодын зохион байгуулалттайгаар тайлант хугацаанд танхим болон цахим хосолсон хэлбэрээр 12 удаа хуралдаж холбогдох тогтоол шийдвэр гаргасан байна.

1.1.9 Мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанаар шийдвэрлэж 2019 онд нийт цэвэр ашиг 43,238.1 сая төгрөг, нэгж хувьцааны ногдол ашиг 821 төгрөг, 2020 онд 31,345.2 сая төгрөгийн цэвэр ашгаас ногдол ашгийг 60 хувиар буюу нэгж хувьцааны ногдол ашиг 357 төгрөг, 2021 онд 13,792.5 сая төгрөгийн ногдол ашиг олгохоор тооцсон байна.

¹ 75.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

² 75.5.Компаний дүрэмд заасан бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл хараат бус гишүүнтэй байж болно.

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

1.1.10 Гурван сайхан орон сууцны корпораци ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааны зохицуулах журам батлаагүй мөн хурлын тэмдэглэл үйлддэггүй байна.

1.1.11 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10³ гэж заасан боловч Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д⁴ санхүүгийн тайланг хийхээр тусгасан нь ойлголтын зөрүүтэй байна.

1.2 Орон нутагт хэрэгжүүлж буй өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлого үр дүнтэй байна

1.2.1 Гүний ус ХХК Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/412 дугаар тушаалаар баталсан Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.1 дэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд 2019 онд хөндлөнгийн аудит хийлгэж сайн үнэлгээ авсан байна.

1.2.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 75 дугаар тогтоол, 2021 оны 204 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчит “Өмнөговь гурван сайхан орон сууцны корпораци ХХК-ийн орон сууцыг түрээслэн, өмчлүүлэх” журам, 2021 оны 49 дүгээр тогтоолоор “Шинэ мянган айл” орон сууцны хөтөлбөрийг тус тус батлуулсан байна.

1.2.3 Гүний ус ХХК компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх талаар 2019-2023 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан удирдлага, менежментийг сайжруулах талаар жил бүр ТУЗ нь гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулж, зорилтот түвшнийг үнэлж, гэрээний үр дүнг дүгнэн, гэрээ байгуулсан байна.

1.2.4 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа илүүдэлтэй ашиглагдахгүй үл хөдлөх хөрөнгүүдийн судалгааг хуулийн дагуу шийдвэрлүүлэн хувьчлалын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №1 2016-2020 онд худалдан хувьчилсан хөрөнгийн судалгаа

Д.д	Хувьчлах эд хөрөнгийн нэр	Шийдвэр гарсан огноо	Байршил, хэлбэр	Хувьчлах эд хөрөнгийн үйл ажиллагааны чиглэл, үл хөдлөх хөрөнгийн зориулалт	Хувьчлагдах эд хөрөнгийн дүн /мян.төгрөг/
1	Сэврэй сумын ЗДТГ-ын контор	2017.02.16	Сэврэй сум төсвийн байгууллага	ЗДТГ-ын хуучин контор	7,980.0
2	Цагдаагийн газрын эзэмшлийн орон сууц	2017.02.16	Ханхонгор сум, төсвийн байгууллага	Орон сууц	8,092.8
3	Гурвантэс сумын ЕБС-ийн орон сууц	2017.02.16	Гурвантэс сум, төсвийн байгууллага	Орон сууц	90,048.0
4	Манлай сумын ЗДТГ-ын орон сууц	2017.02.16	Манлай сум, төсвийн байгууллага	Орон сууц	17,084.8
5	Манлай сумын ЗДТГ-ын орон сууц	2017.02.16	Манлай сум, төсвийн байгууллага	Орон сууц	34,169.6
6	Баяндалай сумын ЕБС-ийн орон сууц	2017.02.16	Баяндалай сум төсвийн байгууллага	Орон сууц	5,678.4

³ аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох

⁴ Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

7	Баяндалай сумын ЗДТГ-ын орон сууц	2019.04.08	Баяндалай сум төсвийн байгууллага	БАМ-ын барилга	61,920.3
8	Мандал-Овоо сумын Аргамжинцэцэг ОНӨААТҮГ-ын барилга	2019.04.08	Мандал-Овоо сум, ОНӨААТҮГ	Эмийн сангийн барилга	18,045.7
9	Мандал-Овоо сумын ЗДТГ -ын граж	2020.04.08	Мандал-Овоо сум, төсвийн байгууллага	7 машины граж	7,091.6
10	Цогт-Овоо сумын Аврахговь ОНӨААТҮГ	2020.04.08	Цогт-Овоо сум, ОНӨААТҮГ	Эмийн сангийн барилга	32,522.1
Дүн					282,633.3

Эх сурвалж: Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн судалгаа

1.2.5 Гүний ус ХХК тусгай зөвшөөрлийн хүрээнд хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй гүйцэтгэх захирал гэрээ байгуулан дүгнүүлсэн байна.

1.2.6 Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоолоор "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай" Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 9 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж, улсын үзлэг, тооллогыг 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн.

1.2.7 Уг шийдвэрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 09 сарын 22-ны өдрийн А-1/1910 албан бичгээр Аймгийн Засаг даргад ирүүлсэн байна. Тооллоготой холбоотойгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/439 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.

1.2.8 Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дарга, нягтлан бодогч, нярав, өмч хамгаалах зөвлөлийн гишүүдийг хамруулсан 540 гаруй албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан байна.

1.2.9 Энэ удаагийн тооллогын давуу тал нь Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Авто тээврийн төвтэй хамтран орон нутгийн өмчит байгууллагуудын хуулийн этгээдийн мэдээлэл, газрын кадастрын зураг, байршил зүйн зураглал, тээврийн хэрэгслийн бүртгэлийн тулгалтыг тулган баталгаажуулалт хийж байгаагаараа тооллогын онцлог болсон байна.

1.2.10 Гүний ус ХХК-ний ӨХБЗ нь төлөвлөгөө гарган, компанийн хагас бүтэн жилийн тооллого болон хөрөнгийн бүртгэл, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажилласан байна.

БҮЛЭГ 2 Хуулийн этгээдүүд удирдлагын зардлаа үндэслэлтэй төлөвлөөгүй нь үр ашиггүй зардал гарах үндэслэл болж байна

2.1 Хуулийн этгээдүүд эдийн засгийн зорилтот түвшнээ үндэслэлтэй төлөвлөдөггүй байна

2.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3⁵ -д заасны дагуу орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд эдийн засгийн зорилтод түвшнээ хангах, компанийн үр өгөөжөө дээшлүүлэх, ажиллах орчин

⁵ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

нөхцөлөө сайжруулах, үйл ажиллагаагаа тэлэх, ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор жил бүр бизнес төлөвлөгөө боловсруулан, түүнийхээ хэрэгжилтийг хангах зорилт тавин ажилласан байна.

2.1.2 Өмнөговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит аж ахуй нэгж 38 байна. Үйл ажиллагааны чиглэлээр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 2 ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл

Үйл ажиллагааны чиглэл	ОНӨААТҮГ-ын тоо
Сумын цэвэр цэмцгэр байдлыг хангах	3
Дулаан үйлдвэрлэл, цахилгаан хангамж зохицуулалтаар хангах	14
Эмийн худалдаа, гоо сайхны барааны жижиглэн худалдаа	15
Хүүхдийн паркийн эвдрэл гэмтэл хариуцах	1
Дулаан үйлдвэрлэл, хангах	1
Удирдлагын ордны тохижилтыг хангах	1
Хөрөнгө оруулалтыг зохицуулах	1
Тээвэр зохицуулалтын үйлчилгээ	1
Хүүхдийн амралт чөлөөт цагийг хангах	1


Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж 2 байна. Үүнд:

Таван толгой ХК	Нүүрс олборлох, борлуулах	1
Гүний ус ХХК	Цэвэр, бохир усны найдвартай хангалт	1

2.1.3 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд бизнесийн орчны нөхцөл, зах зээлийн боломжийг судалсны үндсэн дээр зорилгоо дэвшүүлж, түүнд хүрэхэд шаардлагатай нөөцүүдийг хамгийн үр ашигтай байж болох хувилбараар тооцож бизнес төлөвлөгөөгөө боловсруулах нь зүйтэй байна.

2.1.4 Тавантолгой ХК нь “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, дэвшилтэд технологид тулгуурлан хуулийн хүрээнд, стандартыг ханган, нэр хүндтэй, үр ашигтай Монголын тэргүүлэгч нүүрсний уурхай байхад оршино” гэсэн эрхэм зорилготойгоор байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нүүрс олборлолт, борлуулалт гэж компанийн дүрэмд тодорхойлсон байна.

График №1 Тавантолгой ХК-ийн Монгол Улсын нүүрсний экспортод эзлэх хувь



Эх сурвалж: Тавантолгой ХК үйл ажиллагааны тайлан

2.1.5 Сүүлийн жилүүдэд нүүрсний экспорт буурсан нь дэлхий нийтийг хамарсан цар тахлаас болж хил хаагдсанаас шалтгаалжээ.

2.1.6 Тавантолгой ХК-ний эдийн засгийн зорилтод түвшин, бизнес төлөвлөгөөг компанийн дунд хугацааны хөгжлийн баримт бичиг, техник эдийн засгийн үзүүлэлт, уулын ажлын

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

төлөвлөгөөтэй уялдуулан компанийн санхүү, эдийн засгийн албанаас боловсруулсан байна.

Хүснэгт №3 Тавантолгой ХК-ны техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэл /сая төгрөг/

Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2019		2020		2021	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
Нүүрс олборлолт	мян.тн	6,000.0	2,422.7	5,600.0	2,498.1	5,500.0	1,696.0
Нүүрс борлуулалт	мян.тн	6,000.0	2,240.6	5,150.0	2,355.9	5,140.0	1,280.2
Үүнээс: Экспорт	мян.тн	5,580.0	1,921.2	5,000.0	2,231.7	5,040.0	1,073.4
Дотоод	мян.тн	420.0	319.5	150.0	124.2	100.0	206.8
Хөрс хуулалт	мян.м3	41,200.0	21,673.4	35,722.0	17,756.6	47,400.0	13,464.6
Нийт уулын цул	мян.м3	45,425.4	23,379.7	39,665.7	19,515.8	51,273.2	14,659.0
Борлуулалтын орлого	сая.төг	687,933.0	263,521.8	680,124.3	254,181.2	637,772.9	179,329.5
Нийт зардал	сая.төг	465,029.7	205,612.9	422,930.6	216,079.5	533,829.7	162,877.3
а.Үндсэн үйлдвэрлэл	сая.төг	460,814.0	201,116.4	418,097.8	210,357.2	529,292.0	155,305.8
б. Удирдлагын зардал	сая.төг	2,439.2	2,898.2	2,790.9	3,544.8	3,061.4	3,787.6
в. Туслах үйл ажиллагаа	сая.төг	1,776.5	1,598.3	2,041.9	2,177.5	1,476.3	3,783.9
Татвар төлөхийн өмнөх ашиг	сая.төг	222,903.2	62,667.0	257,328.6	39,972.0	103,943.2	17,549.1
Цэвэр ашиг	сая.төг	167,627.4	48,062.7	193,896.5	31,345.2	81,153.5	13,792.5
Ногдол ашиг хуваарилалт	сая.төг	108,957.8	43,238.2	126,032.7	28,210.6	52,749.8	12,413.2
Ногдол ашиг /сая төгрөг/	51	55,568.5	22,680.6	64,276.7	14,387.4	26,902.4	6,330.7
	49	53,389.3	21,186.6	61,756.0	13,823.2	25,847.4	6,082.5
Ногдол ашиг олгосон хувь		65%	90%	65%	90%	65%	90%

Эх сурвалж: Тавантолгой ХК-ны үйл ажиллагааны тайлан

2.1.7 Хүснэгтээс харахад нүүрс олборлолт 30.8, нүүрс борлуулалт 24.9, хөрс хуулалт 28.4, борлуулалтын орлого 28.1, цэвэр ашиг 17.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь зорилтод түвшиндээ хүрч ажиллаагүйг харуулж байна.

2.1.8 Ногдол ашгийг цэвэр ашгийн 65 хувиар олгохоор төлөвлөсөн боловч орон нутгийн төлөөлөл болон ТУЗ-өөс 90 хувиар тогтоож сүүлийн 3 жил орон нутгийн төсөвт 43,398.7 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилжээ.

2.1.9 Гүний ус ХХК нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулж “Байгалийн баялгийг үр ашигтай ашиглаж, тэнцвэртэй байдлыг хангаж, эрчимтэй хөгжлийг бүтээж, орчин үеийн техник технологийн ололт амжилтад тулгуурлан хэрэглэгчдийг цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулж цэвэршүүлнэ” гэсэн эрхэм зорилготой байна.

Хүснэгт №4 Гүний ус ХХК-ний үйлдвэрлэл, борлуулалт

Он	Хэмжих нэгж	Олборлосон ус	Борлуулсан ус	Усны алдагдал	Алдагдал хувиар
2019	мянган м3	369.1	302.3	66.8	18.1
2020	мянган м3	423.5	346.9	76.5	18.0
2021	мянган м3	549.2	444.17	104.85	19.1

Эх сурвалж: Гүний ус ХХК-ны хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

2.1.10 Олборлосон нийт усны 81 хувийг иргэд, аж ахуй нэгжид борлуулсан байна.

2.1.11 Гүний ус ХХК нь зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төслийн В2: Байгууллагын хөгжил ба чадавхыг сайжруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд 2019-2021 оны стратеги төлөвлөгөөг хянасан байна.

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

2.1.12 Байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан санхүү, эдийн засгийн хяналтын нэгж нь боловсруулж гүйцэтгэх захирлаар хянуулсан байна.

Хүснэгт №5 Гүний ус ХХК-ны үндсэн үзүүлэлт зорилтот түвшин сүүлийн 3 жилийн байдлаар

/сая төгрөг/

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он	
	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
Цэвэр ус	712.4	682.3	640.6	717.8	736.9	883.5
Бохир ус	476.9	461.6	491.6	491.6	630.8	769.5
Суурь хураамж	85.4	87.3	99.7	99.7	85.9	115.4
Бусад орлого	350.9	529.3	401.6	471.7	680.3	492.3
Нийт орлого	1,625.6	1,760.5	1,633.5	1,780.8	2,133.9	2,260.7
Цэвэр борлуулалт	1,138.6	1,231.1	1,231.9	1,309.1	1,453.6	1,768.5
Нийт зардал	1,604.9	1,736.9	1,606.2	1,763.3	2,092.7	2,178.4
а.ББӨ	1,335.9	1,415.1	1,255.1	1,485.3	1,677.4	1,853.6
б. Ерөнхий ба удирдлагын зардал	267.4	277.4	262.3	230.3	278.9	281.8
в. Үйл ажиллагааны бус зардал	1.6	44.4	88.8	47.7	136.4	42.9
Цэвэр ашиг, алдагдал	20.7	23.6	27.3	17.5	41.2	82.3
Олгосон ногдол ашиг 51		2.40		0.88		0.95
Олгосон ногдол ашиг 49		2.30		0.85		0.91
Ногдол ашиг олгосон хувь		20%		10%		10%

Эх сурвалж: Гүний ус ХХК-д хийсэн аудитын тайлангаас

2.1.13 Гүний ус ХХК-ний хувьд борлуулалтын орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн ч төлөвлөсөн нийт зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь үйлдвэрлэлийн нөөц боломжийг бүрэн тооцож, бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулаагүй гэж үзэхэд хүргэж байна.

2.1.14 ОНӨААТҮГ-ууд урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичиг, стратеги төлөвлөгөө боловсруулаагүй байгаа нь эдийн засгийн зорилтод түвшин, бизнес төлөвлөгөөгөө үндэслэлтэй төлөвлөхөд учир дутагдалтай байна.

2.1.15 Цаашид ОНӨОААН, ОНӨААТҮГ-ууд эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшинг тооцохдоо мэргэжлийн байгууллага, шинжээчтэй хамтран гадаад, дотоод хүчин зүйлсийг тооцож үндэслэлтэй төлөвлөж хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Эдийн засгийн зорилтод түвшнийг тодорхойлохдоо мэргэжлийн байгууллагаар хянуулж, санхүүгийн шинжилгээ хийгээгүй байна

2.1.16 Компанийн үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалтын үр ашгийг дээшлүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулах, эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх захирал, компанийн ТУЗ-тэй, ОНӨААТҮГ-удын захирал аймгийн Засаг даргатай жил бүр гэрээ байгуулан хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт №6 Гэрээний хэрэгжилт

Хуулийн этгээдийн нэр	Гэрээ байгуулж, бизнес төлөвлөгөө баталсан	Гэрээ дүгнэж баталсан	Гэрээний хэрэгжилт		
			2019 он	2020 он	2021 он
Даланзадгадын дулааны цахилгаан станц ТӨХК	ТУЗ, ЭХС	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Хангалттай	Хангалттай	Хангалттай

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

Тавантолгой ХК	ТУЗ	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Хангалттай	Хангалттай	Хангалттай
Гүний ус ХХК	ТУЗ	ТУЗ	Хангалттай	Хангалттай	Хангалттай сайн
Гурвансайхан ОСК	ТУЗ	ТУЗ		Дүгнээгүй	Хангалттай
Цог-Өрнөх ОНӨААТҮГ	АЗД	АЗД	Хангалттай	Хангалттай	Хангалттай
Номдизель ОНӨААТҮГ	АЗД	АЗД	Хангалттай	Хангалттай	Хангалттай
Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ	АЗД	АЗД	Хангалттай	Сайжруулах шаардлагатай	Сайжруулах шаардлагатай
Тэгшдүүрэн тохижилт ОНӨААТҮГ	Батлуулаагүй	Дүгнээгүй			

2.1.17 Дээрхээс харахад орон өмчит хуулийн этгээдүүдийн эрх бүхий байгууллагууд эдийн засгийн зорилтод түвшин, гэрээний үүргээ хангалттай биелүүлсэн гэж үзжээ.

2.1.18 Төрийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд ТУЗ жил бүр дүгнэлт гаргаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмжийг өгсөн байна.

2.1.19 Тавантолгой ХК-ий хувьд бизнес төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх талаар гүйцэтгэх удирдлагын үүргийг тодорхойлон салбарын яам, мэргэжлийн байгууллагаар хянуулж, захирлын зөвлөлөөр хэлэлцүүлнэ гэсэн боловч хэрэгжээгүй байна.

2.1.20 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтод түвшин, бизнес төлөвлөгөөг компанийн ТУЗ, ХБТХОХ, сумын ИТХ-аар тус тус хянуулан батлуулж байгаа ч зорилтод түвшнийг үндэслэлтэй эсэхийг хянасан талаарх баримт нотолгоо байхгүй байна.

Эрх бүхий байгууллагууд эдийн засгийн зорилтод түвшнийг хянаж, батлахдаа тооцоо, судалгаа, дүн шинжилгээ хийхгүй гүйцэтгэх удирдлагын санал болгосноор баталж байна

2.1.21 Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1⁶, компанийн дүрэмд заасныг үндэслэн компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг жил бүр батлуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-с гүйцэтгэх удирдлагад даалгасан байна.

2.1.22 Орон нутгийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн бодлого, зорилт, стратеги, үйл ажиллагааны чиглэлийг зөв оновчтой тодорхойлж техник эдийн засгийн үндэслэл, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан бизнес төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

2.1.23 Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьд эдийн засгийн зорилтод түвшнийг хангахад борлуулалтын үнэ чухал нөлөө үзүүлж байна.

Хүснэгт №7 Тавантолгой ХК-ний борлуулалтын үнэ тогтоолт

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын				Тогтоосон мөнгөн дүн	Мөрдөж эхлэх хугацаа
Огноо	Дугаар	Гарчиг	Агуулга		
2019.01.25	21	Нүүрсний үнэ шинэчлэн тогтоох тухай	Тавантолгой" ХК-ийн нүүрсний уурхайгаас олборлон гадаадын зах зээлд борлуулах нэг тонн коксжих ангиллын нүүрсний үнэ	70.95 ам.дол	2019.02.01

⁶ компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

2019.10.10	17	Үнэ тогтоох тухай	Компанийн нүүрсний уурхайгаас олборлон дотоодын зах зээлд борлуулах нэг тонн эрчим хүчний ангиллын нүүрсний үнэ		38500 төгрөг	2019.10.20
2019.12.07	28	Нүүрсний үнэ шинэчлэн тогтоох тухай	Тавантолгой" ХК-ийн уурхайгаас олборлон гадаадын зах зээлд борлуулах нэг тонн нүүрсний үнэ	Коксжих нүүрс	55 ам.дол	2019.12.16
				Сул коксжих нүүрс /5-р давхарга/	33 ам.дол	
				Сул коксжих нүүрс /8-р давхарга/	19.8 ам.дол	
2020.04.15	37	Нүүрсний үнэ тогтоох тухай	Тавантолгой ХК-ийн уурхайн 8-р давхаргаас олборлосон сул коксжих нүүрсийг үйлдвэрлэлийн зориулалтаар /авто замын ажил, дахин боловсруулан ашиг олох/ дотоодын зах зээлд борлуулах үнэ		76000 төгрөг	2020.04.15
2020.07.25	18	Нүүрсний үнэ тогтоох тухай	"Тавантолгой" ХК-ийн нүүрсний уурхайгаас олборлон гадаадын зах зээлд борлуулах нэг тонн коксжих ангиллын нүүрсний үнэ		52 ам.дол	2020.08.01
2021.03.04	4/21	Нүүрсний үнэ өөрчлөн тогтоох тухай	"Тавантолгой" ХК-ийн нүүрсний уурхайгаас олборлон гадаадын зах зээлд борлуулах нэг тонн коксжих ангиллын нүүрсний үнэ		55 ам.дол	2021.01.04
2021.04.20	7	Нүүрсний үнэ тогтоох тухай	"Тавантолгой" ХК-ийн уурхайн нүүрсний овоолгод байршуулсан зах зээлд борлуулах нэг тонн сул коксжих ангиллын нүүрс		18.7 ам.дол	2021.04.20
2021.04.20	8	Нүүрсний үнэ тогтоох тухай	Тавантолгой ХК-ийн уурхайгаас олборлосон сул коксжих нүүрсийг үйлдвэрлэлийн зориулалтаар /авто замын ажил, дахин боловсруулан ашиг олох/ дотоодын зах зээлд борлуулах үнэ		49500 төгрөг	2021.04.20
2021.09.24	20	Хөрс хуулалтын зардлын хэмжээг өөрчлөх тухай	Компанийн үндсэн үйлдвэрлэлийн хүрээнд хийгдэх 1 метр куб хөрс хуулалтын зардлын хэмжээг НӨАТ-ыг багтаан тогтоох		6400 төгрөг	2021.10.01
2021.09.24	21	Нүүрсний үнийг шинэчлэн тогтоох тухай	Тавантолгой" ХК-ийн уурхайгаас олборлон гадаадын зах зээлд борлуулах нэг тонн нүүрсний үнэ	Коксжих нүүрс	70.73 ам.дол	2021.09.27
				Коксжих нүүрс /5-р давхарга/	45.1 ам.дол	
				Сул коксжих нүүрс	37.18 ам.дол	
				Коксжих чанаргүй нүүрс /эрчим хүчний/	19.8 ам.дол	
2021.10.20	28	Нүүрсний үнийг шинэчлэн тогтоох тухай	Тавантолгой" ХК-ийн уурхайгаас олборлон гадаадын зах зээлд борлуулах нэг тонн нүүрсний үнэ	Коксжих нүүрс	150.7 ам.дол	2021.10.21
				Коксжих нүүрс /5-р давхарга/	90.2 ам.дол	
				Сул коксжих нүүрс	73.7 ам.дол	
				Коксжих чанаргүй нүүрс /эрчим хүчний/	39.6 ам.дол	
				Овоолго /5-р давхарга/	41.25 ам.дол	
2021.11.22	29	Нүүрсний үнийг шинэчлэн тогтоох тухай	Тавантолгой" ХК-ийн уурхайгаас олборлон гадаадын зах зээлд борлуулах нэг тонн нүүрсний үнэ	Коксжих нүүрс	102.3 ам.дол	2021.11.23
				Коксжих нүүрс /5-р давхарга/	82.5 ам.дол	
				Сул коксжих нүүрс	66.0 ам.дол	
				Коксжих чанаргүй нүүрс /эрчим хүчний/	34.1 ам.дол	
				Овоолго /5-р давхарга/	35.75 ам.дол	

Эх сурвалж: Тавантолгой ХК-ний ТУЗ-ын тогтоол

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

2.1.24 Нүүрсний үнэд нүүрсний чанар, хилийн хаалттай байдал, харилцагч талуудын худалдан авалт, АМНАТ нэмэгдсэн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж, нүүрсний үнийг 2019 оноос хойш 12 удаа өөрчилсөн байна.

2.1.25 Гүний ус ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, суурь хураамжийг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 78 дугаар тогтоолоор баталж, 2020 оны 107 дугаар тогтоолоор Даланзадгад сумын төсөвт байгууллагад мөрдөх цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг, 2021 оны 125 дугаар тогтоолоор Даланзадгад сумын төвийн үйлдвэр, аж ахуй нэгж байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээ, бохир усны үйлчилгээний суурь хураамжийг тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт №8 Цэвэр, бохир усны үнэ, үйлчилгээний тариф, суурь хураамж

Хэрэглэгчдийн төрөл	Төлбөрийн төрөл	Хэмжих нэгж	Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоол		
			2017 оны 78	2020 оны 107	2021 оны 125
Төсөвт байгууллага	Цэвэр ус	төг/л		4.5	
	Бохир ус	төг/л		5.2	
ААНБ	Цэвэр ус	төг/л	3.5		4.5
	Бохир ус	төг/л	2.4		5.2
Хүн ам	Цэвэр ус	төг/л	1.2		
	Бохир ус	төг/л	1.2		
Ус түгээх байр	Цэвэр ус	төг/л	1.8		
Үйлчилгээний суурь хураамж	Цэвэр ус	төг/сар	1800		

Эх сурвалж: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоол

2.1.26 Гүний ус ХХК-ны захирлын 2017 оны 150 дугаар тушаалаар баталсан үйлчилгээний төлбөрийг 2021 оны 5-255 дугаар тушаалаар шинэчлэн тогтоож үйлчилгээний төлбөрийн хэмжээг 10-30 хувиар нэмэгдүүлэн баталсан байна.

2.1.27 Гүний ус ХХК-ний үйлдвэрлэл, үйлчилгээний үнэ, тариф нэмэгдсэнтэй холбоотойгоор 2021 оны борлуулалтын орлого өмнөх оноос 26.9 хувиар өссөн байна.

2.1.28 Энэ нь орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын ашигт ажиллагаа, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд үнийн бодлого, зохицуулалт чухал болохыг харуулж байна.

2.1.29 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааны үнэ тарифыг төрөөс тогтоож, зохицуулж байгаа нь хэрэглэгчдээ дэмжсэн бодлого ч нөгөө талаараа хуулийн этгээдийн үйл ажиллагааны тэнцвэрт байдлыг алдагдуулах эрсдэлийг дагуулж байна.

2.1.30 ОНӨААТҮГ-уудын хувьд эдийн засгийн зорилтод түвшин, бизнес төлөвлөгөөг аймгийн Засаг дарга баталж, улмаар ХОХБТХ, эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн хяналт тавьж, чиг үүргээр хангаж ажиллахаар зохицуулагдсан байна.

2.1.31 Өмнөговь гурван сайхан орон сууц корпораци ОНӨААТҮГ нь аймгийн хэмжээнд иргэдийг орон сууцжуулах талаар баримталж байгаа бодлого, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон сууцаар хангах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бизнес төлөвлөгөөгөө ТУЗ-өөр батлуулан ажилласан боловч Компанийн тухай хуулийн 76⁷ дугаар зүйл,

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

компанийн дүрмийн 9.3.2⁸-д заасныг тус тус үндэслэн 2020, 2021 оны эцэст бизнес төлөвлөгөөг тодотгон, бууруулж баталсан байна.

2.1.32 ОНӨААТҮГ-ууд орлого даван биелсэн тохиолдолд төлөвлөөгүй зардал гаргах, бизнес төлөвлөгөөг дураараа өөрчлөх, өөрчлөн батлуулах зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байна.

2.1.33 Энэ нь эрх бүхий байгууллагууд эдийн засгийн зорилтод түвшнийг хянаж, батлахдаа тооцоо, судалгааг үндэслээгүй, тэдгээрийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашгийг бүрэн тооцоогүйтэй холбоотой байна.

2.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд орлого бүрдүүлэхэд нөөц бололцоог ашиглаж ажилласан байна

2.2.1 ОНӨААТҮГ-ын хувьд тухайн орон нутгийнхаа төсөл хөтөлбөр, худалдан авах ажиллагаанд оролцож нэмэлт орлого бүрдүүлсэн байна.

2.2.2 Орон нутагт тендерт орохын тулд дулаан борлуулалтаас өөр чиглэлээр тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагааныхаа хамрах хүрээг тэлж, орлогоо нэмэгдүүлж байгаа сайн туршлагууд байна. Жишээлбэл: Дулаан, цэвэр бохирын шугам сүлжээний засвар үйлчилгээ, гэрэлтүүлэг, ЦДШ, төрөл бүрийн сантехник, барилгын засвар үйлчилгээнүүд гэх мэт ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №9 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Хуулийн этгээдийн нэр	2019 он		2020 он		2021 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Тавантолгой ХК	687,933.0	263,521.8	680,124.3	254,181.2	637,772.9	179,329.5
Гүний ус ХХК	1,625.6	1,760.5	1,633.5	1,780.8	2,133.9	2,260.7
Гурвансайхан ОСК	-	-	162.2	163.0	299.5	262.8
Цог-Өрнөх ОНӨААТҮГ	894.5	910.5	612.6	711.5	804.0	904.7
Тэгшдүүрэн тохижилт ОНӨААТҮГ	281.1	344.3	466.1	377.9	395.0	365.3
Номдизель	239.7	221.9	320.3	327.6	355.5	362.4
Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ	1,236.4	1,324.9	2,980.0	2,039.7	1,840.0	2,236.3

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.2.3 Хүснэгтээс харахад орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлж ажилласан ч Тавантолгой ХК-ий хувьд цар тахлын улмаас экспортын борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүй нь орлого тасрахад нөлөөлжээ.

2.2.4 ОНӨААТҮГ-уудын хувьд тухайн суманд ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өрсөлдөгч байхгүй тул эрэлт, нийлүүлэлт тогтвортой, байгууллагын хууль эрхзүй, гадаад, дотоод орчны эрсдэл харьцангуй багатай байна.

2.2.5 Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд насжилт өндөр, авлага ихтэй байгаа ба энэ хэмжээгээр төлөвлөсөн орлого нэмэгдэх боломжтой байжээ.

Хүснэгт №10 Санхүүгийн тайланд тусгасан авлага /сая төгрөг/

Хуулийн этгээдийн нэр	2019 он	2020 он	2021 он
Тавантолгой ХК	26,666.1	16,707.8	18,656.5
Гүний ус ХХК	46.9	57.0	377.3
Гурвансайхан ОСК ОНӨААТҮГ	0	0	2.7

⁸ Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагдсан зорилтот төвшнийг үндэслэн бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

Цог-Өрнөх ОНӨААТҮГ	9.4	33.7	64.8
Тэгшдүүрэн тохижилт ОНӨААТҮГ	0.2	3.6	4.2
Номдизель ОНӨААТҮГ	0.3	3.3	5.9
Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ		67.8	52.1

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.2.6 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд авлага барагдуулах талаар ажил зохион байгуулж ажилласан хэдий ч цар тахлаас үүдсэн улс орны эдийн засгийн хямрал, ард түмний амьжиргааны түвшин буурч байгаатай холбоотойгоор авлагын хэмжээ өссөн байна.

Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлсон эсэхийг татварын албаар хянан баталгаажуулах нь зүйтэй

2.2.7 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд нь холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлж, татвар ногдуулалт, төлөлттэй холбогдсон харилцааг тухайн төрлийн татварын хуулиар зохицуулж байна.

Хүснэгт №11 Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, төлбөрийн дүн
/сая төгрөгөөр/

Хуулийн этгээдийн нэр	Төвлөрүүлсэн төсөв	Төвлөрүүлсэн татварын дүн		
		2019 он	2020 он	2021 он
Тавантолгой ХК	Орон нутгийн төсөв	847.2	824.2	1,054.9
	Улсын төсөв	93,392.3	59,214.0	48,794.1
Гүний-Ус ХХК	Орон нутгийн төсөв	58.5	65.5	82.3
	Улсын төсөв	118.0	122.3	85.5
Цог-Өрнөх ОНӨААТҮГ	Орон нутгийн төсөв	22.7	18.4	21.1
	Улсын төсөв	43.7	44.4	53.8
Тэгш дүүрэн тохижилт ОНӨААТҮГ	Орон нутгийн төсөв	8.7	12.1	12.0
	Улсын төсөв	16.4	27.4	25.8
Номдизель ОНӨААТҮГ	Орон нутгийн төсөв	8.7	10.9	11.2
	Улсын төсөв	21.3	26.0	25.2
Гурвансайхан ОСК ОНӨААТҮГ	Орон нутгийн төсөв	-	3.5	5.5
	Улсын төсөв			10.9

Эх сурвалж: Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн судалгаа

2.2.8 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн харьяа татварын албандаа бүртгүүлэн татварт хамрагдсан байна.

2.2.9 Татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлсон эсэхийг энэ аудитаар бүрэн тодорхойлох боломжгүй байна.

2.2.10 Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татварын өр өндөр дүнтэй байгаа хэдий ч тайлант жилдээ төлж барагдуулан насжилт үүсгээгүй байна.

Хүснэгт №12 Санхүүгийн тайланд тусгасан татварын өр /сая төгрөг/

Хуулийн этгээдийн нэр	Татварын өглөг		
	2019 он	2020 он	2021 он
Тавантолгой ХК	15,302.4	24,790.1	49,901.3
Гүний ус ХХК	31.3	22.7	83.1

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

Цог-Өрнөх ОНӨААТҮГ			
Тэгш дүүрэн тохижилт ОНӨААТҮГ		1.3	-
Номдизель ОНӨААТҮГ	-	-	0.6
Гурвансайхан ОСК		0.2	0.2
Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ		6.4	106.0

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.2.11 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд татвар төлөгчийн үүргээ хэрэгжүүлж улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх албан татвар, төлбөр, хураамжийг хуулиар тогтоосон хугацаандаа төлж барагдуулахад анхаарч ажиллах нь зүйтэй.

2.2.12 Татварын албаны etax.mta.mn/ сайтын татварын тодорхойлолтоор ОНӨОААН, ОНӨААТҮГ-ууд урд оны болон тайлант оны татварын илүү, дутуу төлөлттэй байгаа ба энэ нь санхүүгийн тайланд тусгагдсан өр, авлагын дүнтэй тохирохгүй байна.

2.2.13 Иймд дотоод хяналтыг сайжруулж аймгийн татварын хэлтэстэй татварын нэр төрлөөр тооцоо нийлж, ногдуулалт, төлөлтийн зөрүүг арилгаж татварын өр, илүү төлөлтийг баталгаажуулж ажиллах шаардлагатай.

2.3 Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах шаардлагатай байна

2.3.1 Түүврээр үзсэн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд их хэмжээний хэлцлийг өөрийн байгууллагын дүрмээр тодорхойлоогүй бөгөөд компанийн тухай хуулиар тодорхойлсон их хэмжээний хэлцэл хийгээгүй байна.

2.3.2 Гүний ус ХХК, Таван толгой ХК 2019-2021 онуудад гаргасан ТУЗ-ийн тогтоолд их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тогтоол гаргаагүй байна.

2.3.3 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүд удирдлагын зардлыг оновчтой төлөвлөөгүй нийтлэг зөрчил байна. Үүнд:

- Өмнөговь Гурван сайхан орон сууцны корпораци ХХК нь ТУЗ-ын 2020 оны 08 дугаар тогтоолоор баталсан 2020 оны бизнес төлөвлөгөөнд удирдлагын зардал ББӨ-г тусад нь төлөвлөөгүй,
- Тэгш дүүрэн ОНӨААТҮГ 2019 оны бизнес төлөвлөгөөнд удирдлагын зардал ББӨ-г тусад нь төлөвлөөгүй, 2021 онд байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй,
- Тавантолгой ХК нь 2019-2020 онд үндэслэл тодорхойгүй, хууль эрх зүйн чадамжгүй, хавсралтгүй, хурлын тэмдэглэл, иргэд аж ахуй нэгжээс ирсэн өргөдөл нотлох баримтаар баталгаажуулж нийт 1,840.8 сая төгрөг зарцуулсан байна.

2.3.4 Түүвэрт хамрагдсан байгууллагууд үр ашиггүй орон тоо бий болгосон, Төсвийн хэмнэлтийн талаар зарим арга хэмжээний тухай тогтоолыг зөрчин хандив тусламж, урамшуулал, орон тоог нэмэгдүүлсэн, олон жилийн авлага барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, тамирчдыг цалинжуулсан, тооцооллын алдаанаас шалтгаалан арвилан хэмнэлтгүй ажилласан байна. Тухайлбал:

- Өмнөговь гурван сайхан орон сууцны корпораци ХХК нь 2021 онд гүйцэтгэх захирал, дэд захирал, инженер, нягтлан бодогч, ашиглалт борлуулалт хариуцсан мэргэжилтэн, нярав, бичиг хэрэг нийт 7 ажилтантай нэмж баталсан,
- Цог-Өрнөх ОНӨААТҮГ 2021 онд МУ-ын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг зөрчин 5.2 сая төгрөгийн их засвар 9.1 сая төгрөгийн автомашин, компьютер техник хэрэгсэл бэлтгэсэн,

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

- Таван толгой ХК нь 2019 онд 4 тамирчинд 34.8 сая, 2020 онд 5 тамирчинд 55.4 сая, 2021 онд 9 тамирчинд 107.4 сая нийт 197.6 сая төгрөгийн цалин олгож үр ашиггүй зардал гаргасан
- Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ нь төсөл хөтөлбөр, тогтоол шийдвэр хэрэгжүүлэх хүрээнд -7, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байр ашиглалт -9, Засаг даргын тамгын газарт гэрээгээр ажиллах мэргэжилтэн -4 нийт 20 орон тоо нэмж баталсан байна.

2.3.5 Цаашид нийгмийн хариуцлагын хүрээнд гэсэн нэрийн дор зарцуулж байгаа хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг тооцож байх шаардлагатай байна.

БҮЛЭГ 3 Хуулийн этгээдэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна

3.1 Сайн засаглалыг төлөвшүүлэхэд төрийн байгууллагуудийн хяналт, оролцоо чухал байна

3.1.1 Тавантолгой ХК нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2⁹ дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам”, гүйцэтгэх захирлын баталсан “Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

3.1.2 Хяналт шалгалтын ажил нь ажлын цагийн ашиглалт, чөлөө зөвшөөрөл, хөдөлмөрийн гэрээ, үндсэн хөрөнгө, сэлбэг, хүнсний нярвуудын тайлан тооцоо бүртгэл хөтлөлт, туслан гүйцэтгэх компаниудын хөрс хуулалт, тэсэлгээ, механик зэрэг чиглэлүүдийг хамарсан байна.

3.1.3 Тавантолгой ХК-ийн дүрэмд заасны дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь

- Компанийн НББ-ийн бодлого болон НББОУС-д нийцсэн байдал, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл, бусад тайлангийн мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийх,
- Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох,
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, хийгдэх шалгалтын талаар чиг үүрэг өгч гэрээнд тусгах,
- Их хэмжээний сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих гэсэн чиг үүрэгтэй ажиллахаар заасан ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.4 ОНӨААТҮГ-ууд нь “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.4.2¹⁰-д заасны дагуу аймгийн Засаг даргаар батлуулаагүй байна.

Хүснэгт №13 Төрийн байгууллагуудын хийсэн хяналт, шалгалтын тоо

Хуулийн этгээдийн нэр	Шалгалтад хамрагдсан он	СЯ	МХГ	БОАЖГ	ТХ	НДХ	ТӨБЗГ /ЭХЗЗ/	ОНӨГ
Тавантолгой ХК	2019			1				
	2020			1				

⁹ Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ.

¹⁰ өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид мөрдөх “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг аймаг, нийслэлийн Засаг дарга.

	2021		1	1				
Гүний ус ХХК	2019							
	2020		2		1			
	2021		1					
ӨГОСК ОНӨААТҮГ	2020							
	2021							
Цог-Өрнөх ОНӨААТҮГ	2019							
	2020							
	2021		1					
Тэгшдүүрэн тохижилт ОНӨААТҮГ	2019							
	2020							
	2021							
Номдизель ОНӨААТҮГ	2019							
	2020							
	2021		1					
Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ	2019							
	2020							
	2021							

Эх сурвалж: МХГ, БОАЖГ, ТХ-ээс ирүүлсэн мэдээлэл

3.1.5 Дээрх хүснэгтээс харахад эрх бүхий байгууллагуудын хийсэн хяналт шалгалтын тоо бага байгаа нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

3.1.6 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийх төрийн байгууллагуудын хяналт хангалтгүй байна.

3.1.7 Тавантолгой ХК-ий хувьд 2018 онд:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны 04 дүгээр 11-ний өдрийн А/111 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу,
- Сангийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 109 дүгээр тушаалаар баталсан ажлын хэсэг Тавантолгой ХК, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хооронд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас хил даван нүүрс олборлосон асуудлыг шалгаж, дүгнэлт гаргах,
- Гаалийн ерөнхий газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 63/18 дугаартай тушаалаар баталсан бүрдүүлэлтийн дараах шалгалтын удирдамжийн дагуу,
- Татварын ерөнхий газрын дэд даргын 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 018/03 дугаартай тушаалаар баталсан Хяналт шалгалтын ажлын удирдамжийн дагуу,
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын баталсан 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/108 дугаартай тушаалаар баталсан удирдамжийн дагуу,
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/174 дүгээр тушаалаар баталсан шалгалтын удирдамжийн дагуу тус тус хяналт, шалгалтад хамрагдсан байна.

3.1.8 Өмнөговь аймгийн татварын хэлтсээс Гүний ус ХХК-ийн 2016-2019 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтыг хийж татварын хууль тогтоомжийг зөрчсөн 294.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж 37.2 сая төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоосон байна.

3.1.9 Энэ нь орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд татварын хяналт шалгалт хийхэд зөрчил илрэх эрсдэл байгааг харуулж байна.

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

3.1.10 Өмнөговь аймгийн МХГ-аас Тавантолгой ХК, Гүний ус ХХК, Цог-Өрнөх ОНӨААТҮГ-т төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчил арилгуулах тухай улсын байцаагчийн албан шаардлага, зөвлөмж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.

3.1.11 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдэд МХГ-аас эрсдэлд суурилсан, төлөвлөгөөт хяналт шалгалтыг давтан хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарсан ч зөрчил дутагдал, бүрэн арилаагүй байдаг нь хяналтын үр нөлөөг бууруулж байна

3.1.12 Өмнөговь аймгийн БОАЖГ-аас БОАЖС-ын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журам"-ын дагуу Тавантолгой ХК-ны "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"-ний биелэлтэд дүгнэлт өгсөн байна.

3.1.13 Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь улсын байцаагчийн эрх, үүргийн хүрээнд хяналт шалгалтыг хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, эрсдлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хяналт шалгалт хийсэн байна.

Хүснэгт №14 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хэрэгжүүлсэн шалгалт

Хуулийн этгээдийн нэр	2019 он	2020 он	2021 он
	Төлбөрийн акт /сая төгрөг/	Цаашид анхаарах асуудал /тоогоор/	
Гурвансайхан ОСК		3	
Цог-Өрнөх ОНӨААТҮГ	0.3	4	
Тэгшдүүрэн тохижилт ОНӨААТҮГ	1.8	9	2
Номдизель		4	
Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ			0.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 36.0 сая төгрөгийн албан шаардлага 7

Эх сурвалж: Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн судалгаа

3.1.14 Танилцуулгын хуудсаар хяналт шалгалтын дүгнэлт, цаашид анхаарч ажиллах асуудлыг хүргүүлэн хэрэгжилтийг тодорхой хугацааны дараа тооцдог байна.

3.1.15 Санхүүгийн хяналт, аудитын алба нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гүйцэтгэж зөрчлийг тухай бүр арилгуулахад анхаарч ажилласан ч зөрчил дутагдал давтан гарсаар байна.

3.1.16 Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2018 оны А/06 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Таван толгой ХК-ий 2009-2016 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийсэн байна.

3.1.17 Тус аудитаар 344,376.3 сая төгрөгийн 15 зөрчлийг илрүүлж 46.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 344,329.6 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн байна.

3.1.18 Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1¹¹-д гэж заасны дагуу орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас жил бүр аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

3.1.19 Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа,

¹¹ Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэл, зөвлөмжийг толилуулсан байна.

Хүснэгт № 15 Хуулийн дагуу хийгдсэн санхүүгийн тайлангийн аудит

/сая төгрөг/

Хуулийн этгээдийн нэр	Хамрах он	Дүгнэлт	Аудитаар илэрсэн зөрчлийн дүн	Аудитаар өгсөн	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Аудит хийсэн байгууллага
Тавантолгой ХК	2019	Зөрчилгүй	27.5	Зөвлөмж 1	75	Юнистар аудит ХХК
	2020	Зөрчилгүй	6,072.6	Төлбөрийн акт 1, албан шаардлага 1, зөвлөмж 10	80	Ихмонгол хөлөг аудит ХХК
	2021	Зөрчилгүй	8,390.2	Нийцлийн аудитын албан шаардлага 1, зөвлөмж 1, санхүүгийн аудитын албан шаардлага зөвлөмж	95	Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Гүний ус ХХК	2019	Зөрчилгүй				Гэрэлт Хөхийн тэнцвэр ХХК
	2020	Зөрчилгүй	15.8	Зөвлөмж 4	100	Монголиан бизнес рейтинг аудит ХХК
	2021	Зөрчилгүй	8.2	Зөвлөмж 2	100	Монголиан бизнес рейтинг аудит ХХК
Өмнөговь гурван сайхан орон сууцны корпораци ОНӨААТҮГ	2020	Зөрчилгүй	526.1	Зөвлөмж 2	Өмнөх онд аудитаар ороогүй	Эс Эм аудит ХХК
	2021	Зөрчилгүй	15.0	Зөвлөмж 1	100	Азуре Хүлүг Аудит ХХК
Цог-Өрнөх ОНӨААТҮГ	2019	Зөрчилгүй	8.5	Зөвлөмж 5		Эс Жи Эм Ди аудит ХХК
	2020	Зөрчилгүй	4,086.8	Зөвлөмж 4	Зөвлөмж өгөгдөөгүй байна.	Ихмонгол хөлөг аудит ХХК
	2021	Зөрчилгүй	83.3	Нийцлийн аудитын албан шаардлага 1, санхүүгийн аудитын албан шаардлага 1, зөвлөмж 4	100	Эн Ай Ти Эс баланс аудит ХХК
Тэгшдүүрэн тохижилт ОНӨААТҮГ	2019	Зөрчилгүй	7.6	Зөвлөмж 5	Зөвлөмж өгөгдөөгүй байна.	Эс Жи Эм Ди аудит ХХК
	2020	Зөрчилгүй	17.4	Төлбөрийн акт 1, Зөвлөмж 2	100	Ихмонгол хөлөг Аудит ХХК
	2021	Зөрчилгүй	73.4	Нийцлийн аудитын албан шаардлага 1, санхүүгийн аудитын албан шаардлага 1, зөвлөмж 3	75	Эн Ай Ти Эс баланс аудит ХХК
	2019	Зөрчилгүй	-	Албан шаардлага 1		Интер аудит ХХК

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

Номдизель ОНӨААТҮГ	2020	Зөрчилгүй	563.4	Зөвлөмж 4	Зөвлөмж өгөгдөөгүй байна.	Ихмонгол хөлөг Аудит ХХК
	2021	Түүвэрт хамрагдсан				
Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ	2019	Зөрчилгүй	23.9	Зөвлөмж 4	31.5	Бэст фортуна аудит ХХК
	2020	Зөрчилгүй	10.0	Зөвлөмж 6	44.8	ӨМТАГ
	2021	Хязгаар- лалттай санал дүгнэлт	617.1	Нийцлийн аудитын албан шаардлага 1, санхүүгийн аудитын албан шаардлага 1, зөвлөмж 5	70	Азуре Хүлүг Аудит ХХК

Эх сурвалж: Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар

3.1.20 Хүснэгтээс харахад орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитыг ихэнх тохиолдолд аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн байна.

3.1.21 Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцоход дунджаар 80.9 хувьтай байгаа ба хуулийн этгээд бүр харилцан адилгүй биелүүлсэн байна.

3.1.22 Мөн санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай санал дүгнэлт” авсан шалгагдагч байгууллагад хариуцлагын арга хэмжээ тооцохгүй байгаа нь аудитын үр нөлөөг бууруулж, зөрчил давтан гаргах нөхцөлийг бүрдүүлж байна.

3.1.23 Аудитад хамрагдсан байгууллагууд дотоод аудитын нэгжгүй байна.

3.2 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг бүрэн хангаагүй байна

3.2.1 Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөө гарган, байгууллагын хагас, бүтэн жилийн тооллого болон хөрөнгийн бүртгэл, ашиглалт хамгаалалтад хяналт тавьсан байна.

3.2.2 Таван толгой ХК 2021 онд орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөл, шийдвэр гаргуулалгүй ТУЗ-ын 2021 оны №27 дугаар тогтоолоор 4.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

3.2.3 Номдизель ОНӨААТҮГ, Цог-Өрнөх ОНӨААТҮГ, Өмнөговь Гурван сайхан орон сууцны корпораци ХХК үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангаа ил тод мэдээлээгүй, албан ёсны веб хаяггүй байна.

3.2.4 Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн^{12 13 14 15 16} заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Нийтлэг илэрсэн зөрчлийг дурдвал:

¹² 5.1 "Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна

¹³ 5.1.1 шилэн дансны бие даасан цэстэй байх;

¹⁴ 5.1.2 мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх

¹⁵ 5.1.3 тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх

¹⁶ 5.1.4 мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх."

- Цог-Өрнөх ОНӨААТҮГ 2021 онд 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, 17.2 сая төгрөгийн мэдээлэл байршуулаагүй,
- Өмнөговь Гурван сайхан орон сууцны корпораци ХХК 2021 онд 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн 14.6 сая төгрөгийн 2 мэдээлэл байршуулаагүй, 1 мэдээлэл 0.4 сая төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн
- Тэгш дүүрэн тохижилт ОНӨААТҮГ 2019 онд 28 мэдээлэл, 2020 онд 6 мэдээлэл, 2021 онд 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн 2 мэдээлэл байршуулаагүй,
- Гүний ус ХХК 2019 онд 9 мэдээлэл, 2020 онд 6 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн,
- Таван толгой ХК компанийн веб хуудсыг ажиллуулж 2019, 2020 оны үйл ажиллагааны тайланг мэдээлсэн боловч 2021 оны үйл ажиллагааны тайланг мэдээлээгүй,
- Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ 2021 онд 15 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 416.7 сая төгрөгийн 25 гүйлгээ мэдээлээгүй байна.

3.2.5 Байгууллагын үйл ажиллагааны тайлан, шилэн дансанд мэдээллийг тухай бүрд мэдээлж, иргэд олон нийт мэдээллээр хангагдах хөндлөнгийн хяналт тавих боломжийг бий болгох шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна

- Шинээр байгуулж байгаа аж ахуй нэгжүүдийг тооцоо судалгаанд үндэслээгүй байна
- Орон нутагт хэрэгжүүлж буй өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлого үр дүнтэй байна
- Хуулийн этгээдүүд эдийн засгийн зорилтот түвшнээ үндэслэлтэй төлөвлөдөггүй байна
- Эдийн засгийн зорилтод түвшнийг тодорхойлохдоо мэргэжлийн байгууллагаар хянуулж, санхүүгийн шинжилгээ хийгээгүй байна
- Эрх бүхий байгууллагууд эдийн засгийн зорилтод түвшнийг хянаж, батлахдаа тооцоо, судалгаа, дүн шинжилгээ хийхгүй гүйцэтгэх удирдлагын санал болгосноор баталсан байна
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд орлого бүрдүүлэхэд нөөц бололцоог ашиглаж ажилласан байна
- Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлсон эсэхийг татварын албаар хянан баталгаажуулах нь зүйтэй
- Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах шаардлагатай байна
- Сайн засаглалыг төлөвшүүлэхэд төрийн байгууллагуудийн хяналт, оролцоо чухал байна
- Аудитад хамрагдсан байгууллагууд дотоод аудитын нэгжгүй байна.
- Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг бүрэн хангаагүй байна

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга-д

- ОНӨААТҮГ-ууд урт болон дунд хугацааны хөгжлийн баримт бичиг, стратеги төлөвлөгөө боловсруулах
- ОНӨААТҮГ-ууд эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшнийг тооцохдоо мэргэжлийн байгууллага, шинжээчтэй хамтран гадаад, дотоод хүчин зүйлсийг тооцож үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжилтийг хангуулж ажиллах
- Хуулийн этгээдүүд төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлсон эсэхийг татварын албаар хянан баталгаажуулах
- ОНӨААТҮГ-ууд нь “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг баталж, мөрдүүлэх

Өмнөговь Гурван сайхан орон сууцны корпораци ХХК

- Байгууллагын засаглалыг хөгжүүлэхэд төрийн бодлоготой уялдуулан ажиллах
- Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааны зохицуулах журам батлах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд засаглалын чиглэлээр сургалтад хамрагдах
- Дотоод аудитын нэгжтэй болох
- Санхүүгийн шинжилгээг хийж үр ашгийг тооцох

Гүний ус ХХК

- Дотоод аудитын нэгжтэй болох
- Санхүүгийн шинжилгээг хийж үр ашгийг тооцох

Таван толгой ХК

- Дотоод аудитын нэгжтэй болох
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллааг чанаржуулах
- Санхүүгийн шинжилгээг хийж үр ашгийг тооцох

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
“ГҮНИЙ-УС” ХХК**

46080 Өмнөговь аймаг, Даланзадгад хот,
УБД: 1111002038, Ооаа: 7053 3903

2022.07.01 № 5/85
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашгийн аудитад гаргах санал байхгүй болно.

Хавсралт хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЭНХЧИМЭГ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/17

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гуравдугаар газар, Аймгийн Засаг даргад, ОНӨОААН-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагад зөвлөсүгэй.
4. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг ахлах аудитор (Ж.Болормаа)-д үүрэг болгосугай.



Ц.ӨСӨХБАЯР